

КОМПАНИЙН ТУХАЙ

Байгуулагдсан он: 2011
ХК болсон он: 2019

Table with 2 columns: ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, %
Rows: Ард Санхүүгийн Нэгдэл ба хамаарал бүхий компаниуд (62.3%), Олон Нийт (19.2%), С. Гэрэлтуяа (7.5%), Х. Батхишиг (4.0%), С. Оргил (3.8%), Г.Бат-Эрдэнэ (3.1%)

Менежмент:

Гүйцэтгэх захирал: Г. Сүхбаатар
20+ жилийн туршлага

LinkedIn: Suhbaatar Gurragchaa

Гүйцэтгэх удирдлагын баг:

10 гишүүн
10+ жилийн туршлага

Ажилчдын тоо: 52

Эрэгтэй 34.6%, Эмэгтэй 65.4%

ОНЦЛОХ САНХҮҮГИЙН ХАРЬЦААНУУД

Table with 3 columns: ХАРЬЦААНУУД, 2023, 2024
Rows: Өөрийн хөрөнгийн өгөөж ROE (%), Нийт хөрөнгийн өгөөж ROA (%), NPL, Хөрвөх Чадварын Харьцаа, Итгэлцлийн Эздийн Өмчид Эзлэх %, Бонд өөрийн хөрөнгөд эзлэх %, Компанийн хувьцаа өөрийн хөрөнгөд эзлэх %

2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОХ

- Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 84,000,000 ширхэг хувьцааг нэмж гарган FPO хийсэн бөгөөд нэгж хувьцааг 1106-р үнэлэн, нийт 78.9 тэрбумыг татан төвлөрүүлэв.
2024 онд 13.5 тэрбумын нээлттэй бонд гаргах зөвшөөрөл авсан бөгөөд нийт 4 транчтай Ард Кредит Бондоор жилийн 18.5% өгөөжтэй, 3 сар тутамд купон төлөх нөхцөлтэйгөөр 13.5 тэрбумыг амжилттай татан төвлөрүүлэв.
Онлайн зээлийн шинэчилсэн нөхцөл нэвтрүүлж зээлийн гэрээг цахим буюу Ард Апп-р байгуулах болон бусад банкны карт холбох боломжийг бүрдүүлэв.
Sainscore компанитай хамтран FICO онооны системийг онлайн зээлийн скорингд нэвтрүүлэв.
Visa International-тай хамтын ажиллагаа эхлүүлж, ББСБ-ын салбарын анхны дебит картыг хэрэглээнд нэвтрүүлэв.
Ард Кредит ББСБ-ын гуйвуулгын үйлчилгээ нь дэлхийн эдийн засгийн форумын онцлох шийдлээр шалгарав.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ

Монголбанкны зөвшөөрлийн нэр:

- Төлбөрийн карт гаргах
Цахим мөнгө
Аутсорсингийн үйлчилгээ авах

СЗХ зөвшөөрлийн нэр:

- Зээл
Гадаад валютын арилжаа
Итгэлцэл
Хөрөнгө оруулалт
Цахим мөнгө
Финтек зээл

ББСБ-ЫН САЛБАРЫН МАНЛАЙЛАГЧДЫН НЭГ НЭЭЛТТЭЙ ХК


Ард Кредит нь Ард Санхүүгийн Нэгдлийн банкны кластерын голлох нэгж бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрөлтэй, олон нийтэд нээлттэй ББСБ гэдгээрээ онцлог. 2011 онд Монгол дахь санхүүгийн хүртээмжийг өргөжүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа эхлүүлж Ард Санхүүгийн Нэгдлийн хөгжүүлсэн Ард апп дахь мобайл хэтэвчээр дамжуулан Ард Кредит зээлийн скорингийг тогтоож, финтек зээл олгож эхэлсэн. Мөн Ард Санхүүгийн Нэгдлийн экосистем дэх блокчэйн технологид суурилсан бусад үйлчилгээ болох урамшууллын оноо, цахим худалдаа, даатгал, үнэт цаасны арилжаа болон төлбөр тооцооны үйлчилгээнүүдийг багтаасан цогц платформ хэлбэрээр үйлчилгээгээ санал болгодог.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ РҮҮ ЧИГЛЭСЭН АЖЛУУД


Ард Кредит ББСБ нь 2019 онд компанийн 25% болох 70,000,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгож нээлттэй хувьцаат компани болсон. Улмаар 2021 онд Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн I ангилал руу шилжсэн. Мөн сүүлийн 3 жил дараалан ТОП-20 индекст тасралтгүй багтаад байна. 2024 онд компани МХБ дээр нийт 84,000,000 ширхэг хувьцааг нэмж гаргасан бөгөөд нэгж хувьцааг 1106 үнэлэн, нийт 78.9 тэрбумыг татан төвлөрүүлсэн. Татан төвлөрүүлсэн дүнгийн 20%-ийг хэрэглээний зээл, 30%-ийг хөрөнгө барьцаалсан зээл, 50%-ийг бичил болон жижиг, дунд бизнесийн зээлийн санхүүжилтэд зориулахаар төлөвлөсөн ба үүний дагуу 2024 онд нийт активыг 115.8 тэрбум, зээлийн багцыг 70.3 тэрбумд хүргэж нийт 3.6 тэрбумын цэвэр ашигтай ажиллажээ.

ББСБ САЛБАРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсад 2024 оны байдлаар тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 573 ББСБ байгаа бөгөөд финтек зээлийн үйлчилгээ үзүүлж буй 69 ББСБ байна. ББСБ-ын зээлийн багц сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж, сүүлийн гурван жилийн дундаж нь 28.2% хүрчээ. Мөн чанаргүй зээлийн хувь буурч 2024 онд 6.1% болов.



ЗЭЭЛИЙН БАГЦ



Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

Table with 5 columns: сая ₮, 2022, 2023, 2024, YoY%
Rows: Нийт актив (58,039, 72,006, 115,498, 60%), Нийт өр төлбөр (39,989, 51,101, 65,408, 55%), Цэвэр зээл (40,038, 47,942, 68,112, 42%), Итгэлцлийн өглөг (13,466, 24,161, 31,267, 29%)

Орлогын бүтэц

Table with 5 columns: сая ₮, 2022, 2023, 2024, YoY%
Rows: Хүүгийн орлого (11,228, 12,839, 18,609, 43%), Хүүгийн зардал ((6,314), (6,738), (8,773), 27%), Цэвэр хүүгийн орлого (4,914, 6,101, 9,835, 60%), Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3,072, 3,529, 6,979, 112%), Хүүгийн бус орлого (5,766, 6,210, 6,853, -7%), Хүүгийн бус зардал ((5,902), (6,294), (9,401), 22%), Татварын өмнөх ашиг (алдагдал) (2,435, 2,951, 4,431, 50%), Орлогын албан татварын зардал ((375), (433), (497), 15%), Цэвэр ашиг (алдагдал) (2,059, 2,519, 3,934, 56%)

*Аудитлагдаагүй

Яагаад хөрөнгө оруулах вэ?

- Актив болон зээлийн багцын өсөлт: Бүрэн дижитал зээл олголт, зээлийн скорингийн оновчтой процессын үр дүнд зээлийн эрэлт 56.5%-иар тэлэх хүлээлттэй байна. Мөн цаашид гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон зээлийн үйл ажиллагааны өсөлтөөс үүдсэн стратегийн хөрөнгийн хуваарилалтын үр дүнд актив 24%-иар нэмэгдэх төлөвтэй.
Өсөн нэмэгдэж буй харилцагчийн бааз болон зээлийн эрэлт: Орон нутагт бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлснээр зээлийн бүтээгдэхүүний эрэлт идэвхжих ба бизнесийн зээл эрэлттэй байхтай холбоотойгоор зээлийн хэмжээ нэмэгдэх төлөвтэй байна.
Бүтээгдэхүүн хөгжүүлэлт:
1. Ard App: Аппликэйшний хамгийн сүүлийн хувилбар нэвтрэх бөгөөд хувийн санхүүгийн хяналтыг сайжруулах шинэчлэгдсэн санхүүгийн удирдлагын систем бий болно.
2. Хиймэл оюун ухаанд суурилсан дижитал зөвлөх: Санхүүгийн ухаалаг туслах нэвтрүүлж, хэрэглэгчдэд санхүүгээ илүү үр дүнтэй удирдахад тусална.
3. Олон улсын мөнгөн гуйвуулга: 2025 оны I улирлаас эхлэн 180 гаруй улс руу шуурхай олон улсын мөнгөн гуйвуулга хийх боломжийг бүрдүүлнэ.

ФИНТЕК ЗЭЭЛ



Хувьцаа
EPS: 7.8 vs 11 (IPO vs *Одоо)
BVPS: 25.8 vs 102 (IPO vs *Одоо)
P/E: 10.5 vs 11 (IPO vs *Одоо)
P/B: 3.1 vs 1.1 (IPO vs *Одоо)
*2024.12.31 ний байдлаар